## ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

# АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭСЭЭС ӨГСӨН ЗӨВЛӨМЖЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 06 дугаар сарын 14 Залаа

| № | Хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоол, тогтоомж шийдвэр | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (Хувь) | Зорилтот түвшин (Хувь) | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **Нэг. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах талаар:** | | | | | |
| 1.1 | Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системд тайлагнасан 12 төрлийн тайлангийн хэрэгжилтийн үнэлгээгээр үр дүнгүй, эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн нийт 76 арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, захирамжийн хэрэгжилт хангалттүй, хэрэгжээгүй хэрэгжилтүүдэд дүгнэлт хийж, нэмэлт төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг бүрэн хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; | Албан хаагчдад сургалт зөвлөгөө өгч ажиллах | 70.95% | 100 | 2024 оны Хагас жилийн байдлаар зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган, албан хаагчидтай тулж ажиллаж, бүх хүнд нэвтрэх нэр, нууц үгийг олгон өөрсдөөр нь тайлагнуулж хэвшээд байна. Тайлагнасан хэрэгжилтийг Хууль, эрх зүйн мэргэжилтэн хянаж ажиллаж байна. Мөн 2023 оны жилийн эцсийн байдлаар эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн ERP ашиглалт, байгууллагын Ил тод байдлыг сайжруулж, сумын сайт дээр ил тод байхаар заагдсан 98 төрлийн мэдээг байршуулж байна. Төрийн үйлчилгээний оператор ажлын байрыг баталж, 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Ө.Мэнджаргалыг томилж, цахимын ил тод байдлыг хариуцуулж ажиллаж байна. |
| 1.2 | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээг үр дүнд чиглүүлж, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинг тодорхой, байдлаар албан ёсны статистик үзүүлэлтэд суурилж, аймгийн бодлоготой | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, ТЖАХ-ын ГТ боловсруулах | 0 | 100 | Байгууллагын гүййцэтгэлийн төлөвлөгөөг журмын дагуу боловсруулан сумын Засаг даргаар батлуулан ажиллалаа. Мөн төрийн жинхэнэ албан хаагчийн Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлалын талаарх журам өөрчлөгдсөн тул 01 дүгээр сарын 05-ний өдөр 25 албан хаагчдад сургалт, мэдээлэл өгч ажиллалаа. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | уялдуулан тодорхойлох, | аргачлалын талаар сургалт орох | | | |
| 1.3 | Бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, түүний эх үүсвэрийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитой төлөвлөх, төсөвт тусгуулах; | 2024 оны Сумын хөгжлийн төлөвлөгөөний санхүүжилт эх үүсвэрийг ИТХ-аар хэлэлцүүлэх | 0 | 100 | Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 100-р тогтоолоор 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг хэлэлцэн баталлаа. |
| 1.4 | Төрийн албан хаагчдыг сургалтад хамруулах, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулах чиглэлээр төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах; | Төлөвлөгөө гаргах | 59 | 100 | Төрийн албан мэдлэг чадварыг нэмэгдүүлэх хүрээнд Тамгын газар 2024 онд 5,000,000 төгрөгийг томилолтын зардалд төсөвлөсөн. Хагас жилийн байдлаар нийт 2,500,000 төгрөгийг зарцуулсан байна. Мөн байгууллагын сургалтыг дотооддоо зохион байгуулж, сар бүр төлөвлөгөө гарган ажиллалаа. Эрүүл мэндийн төвтэй хамтран 04 дүгээр сарын 29-ний өдөр Урьдчилсан үзлэгт хамрагдаагүй 16 албан хаагчийн нэг талын зардлыг Тамгын газраас гарган хамрууллаа. |
| **Хоёр. Хэрэгжилтийн тайлагналыг сайжруулах талаар:** | | | | | |
| 2.1 | Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг хугацаанд нь бүрэн тайлагнаж хэвших, | Баримт бичгийг хугацаа хоцролгүй, үр дүнтэй тайлагнах | 100 | 100 | 2024 оны Хагас жилийн байдлаар зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган, албан хаагчидтай тулж ажиллаж, бүх хүнд нэвтрэх нэр, нууц үгийг олгон өөрсдөөр нь тайлагнуулж хэвшээд байна. Тайлагнасан хэрэгжилтийг Хууль, эрх зүйн мэргэжилтэн хянаж ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар хугацаа хоцроосон тайлан байхгүй. Хугацаанд нь бүрэн тайлагнасан. Мөн 2024 оны хагас жилийн тайлангуудыг цаглабарын дагуу хугацаанд нь тайлагнаж байна. |
| 2.2 | Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг богино | Хугацаа хоцролгүй, үр дүнтэй | 70 | 100 | 2024 оны хагас жилийн Бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хугацаанд нь оруулсан. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | хугацааны үр дүн, дунд хугацааны үр нөлөөг илэрхийлэх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн, үнэн зөв тайлагнаж байх; | тайлагнах | | | |
| 2.3 | Санхүүжилтийн гүйцэтгэл, эх үүсвэрийг арга хэмжээ бүрээр бүрэн тайлагнаж байх; | Тайланг цаг тухай гаргаж байх | 50 | 100 | 2024 оны эхний хагас жилийн Орон нутаг гүйцэтгэлээр<br>70106-ОН гүйцэтгэх засаглал<br>80101- Үндсэн үйл ажиллагааны зардал-438.385.200<br>80106-Баг хорооны зардал-61170500<br>80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж-1600000<br>81102-Орон нутгийн нөөц хөрөнгө -65250000<br>81701-Байгал орчин хамгаалах, нөхөн сэргээлт-23666920<br>82212-Хур хог хаягдал-8503500 биелэлттэй байна. |
| 2.4 | Аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд тухайн арга хэмжээний хэрэгжилтийг баталгаажуулах нотлох баримтыг хавсаргаж байх | Хэрэгжилтэд албан хаагчид зураг, тайлан мэдээний файлуудыг хавсаргах | 60 | 100 | 2024 оны Хагас жилийн байдлаар зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган, албан хаагчидтай тулж ажиллаж, бүх хүнд нэвтрэх нэр, нууц үгийг олгон өөрсдөөр нь тайлагнуулж хэвшээд байна. Тайлагнасан хэрэгжилтийг Хууль, эрх зүйн мэргэжилтэн хянаж, холбогдох зураг, файл баримтыг хавсаргаагүй бол хяналт тавьж ажиллаж байна. |
| 2.5 | Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг тайлагнахдаа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг хэрхэн хэрэгжүүлсэн үр дүнгээ зөв тайлагнах | Хуулийн дагуу мэдээллүүдийг цахим сайтад ил тод нээлттэй байршуулах | 22.63% | 100 | Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нийтэд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг аймгаас ирсэн заавар зөвлөмжийн үр дүнд мэдээллээ байршуулж, сайжруулж ажиллаж байна. |
| **Гурав. Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах талаар:** | | | | | |
| 3.1 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.12-т заасны дагуу байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарыг заавал ажиллуулж, цахим хуудсаар нээлттэй | Хуулийн дагуу мэдээллүүдийг цахим сайтад ил тод нээлттэй | 22.63% | 100 | Сумын цахим сайтад Ил тод байдлын 98 мэдээллийг заавар зөвлөмжийн дагуу байршуулан ажиллаж байна. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | мэдээлэлтэй танилцах нөхцөлийг бүрэн хангах | байршуулах | | | |
| 3.2 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6- д заасан мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах арга хэмжээ авч ажиллах; | Хуулийн дагуу мэдээллүүдийг цахим сайтад ил тод нээлттэй байршуулах | 22.63% | 100 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан 49 мэдээллийг хугацаанд нь цахимд бүрэн оруулж тайлагнаж байна. |
| **Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, үр нөлөөг сайжруулах талаар:** | | | | | |
| 4.1 | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн зөвлөмжийг хяналтад авч, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах | Төлөвлөгөө боловсруулах | 100 | 100 | Хяналт Шинжилгээ үнэлгээний хэлтсээс өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаа. |
| 4.2 | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт, суурь түвшин болон зорилтот түвшин, хүрсэн үр дүнг үндэслэн үнэн зөв, бодитой үнэлэх; | Хэрэгжилтийг үнэн зөв үнэлэх | 70.95 | 100 | Зөвлөмжийг Шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшингээр төлөвлөж хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаа. |
| 4.3 | Төрийн албан хаагчдыг "Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, тайлагнал" сургалтад хамруулж чадавхжуулах; | Сургалт орох | 50 | 100 | 2023 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хяналт шинжилгээ үнэлгээнээс ирүүлсэн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган ажиллалаа. Үүний хүрээнд албан хаагчидтай тулж ажиллаж, бүх хүнд нэвтрэх нэр, нууц үгийг олгон өөрсдөөр нь тайлагнуулж хэвшээд байна. Тайлагнасан хэрэгжилтийн Хууль, эрх зүйн мэргэжилтэн хянаж ажиллаж байна. 2024 оны хагас жилийн байдлаар хугацаа хоцроосон тайлан байхгүй. Хугацаанд нь бүрэн тайлагнасан. |
| **Тав. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны талаар:** | | | | | |
| 5.1 | Бүх багийн иргэдийн нийтийн хурлыг журамд заасан хугацааны дотор хуралдуулж, дараа онд хийх ажлын жагсаалтыг баталдаг байх | Хурлын зар тараах, иргэдийг ирц бүрэн оролцуулах | 73 | 100 | Зараа 1-дүгээр багийн ИНХ-ыг 06.03-ны өдөр, Уртын гол 2-р багийн ИНХ-ыг 05.28-ны өдөр, Эрдэнэшанд 3-р багийн ИНХ-ыг 06.03-ны өдөр, Эхэнхавцгай 4-р багийн ИНХ-ыг 06.08-ны өдөр тус тус хуралдуулан 2025 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хийгдэх ажлыг БИНХ-аар баталсан. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 5.2 | Сумын Засаг даргын дэргэдэх ажлын хэсгийг 1 дүгээр улиралд багтаан холбогдох мэргэжлийн хүмүүсийг бүрэн оролцуулж байгуулах, захирамжийг удирдлагын мэдээллийн системд тухай бүр оруулж хэвших | Мэдээллийг байршуулах | 73 | 100 | Ажлын хэсгийн 1-р улиралд багтаан 2024.01.31-ны А/07 дугаар захирамжаар томилсон. |
| 5.3 | ОНХС-ийн хөрөнгөөр хийсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн эх үүсвэр, батлагдсан санхүүжилт зэрэг мэдээллийг 2 дугаар сард багтаан сумын албан ёсны цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлдэг байх; | Мэдээллийг сумын албан ёсны цахим сайтад байршуулах | 73 | 100 | 2023 онд хийсэн ажлын тайлангаа Шинэжинст сумын албан ёсны веб хуудсанд байршуулан, ОНХС-ийн санал авах ажлын хүрээнд БИНХ-аар танилцуулан мөн иргэдэд боршур хэбэрээр хүргэсэн. https://www.facebook.com/groups |
| 5.4 | Үнэлгээний хороог хууль, тогтоомжид заасан журмын дагуу байгуулж, ажиллуулах, мэдээллийг тухай бүр УМС болон бусад сувгаар нээлттэй үзэх боломжтой байрлуулах | Мэдээллийг байршуулах | 73 | 100 | Үнэлгээний хороог АЗ-ны эрхтэй гишүүдээр байгуулан ажилуулж, УМС-д байршуулсан. https://user.tender.gov.mn/mn/invitation?year=2024&selGovernorId=135&selClientId=1488794502497&get=1 |
| 5.5 | ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн үр дүнг тухай бүр УМС-д оруулж, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгож байх | Мэдээллийг байршуулах | 73 | 100 | Энэ онд хэрэгжиж эхэлсэн төсөл хөтөлбөрүүдийн үр дүнг тухай бүр УМС-д байршуулан санхүүжилтийг гэрээнд заасны дагуу олгосон. https://onhs.mof.gov.mn/mis/Report/HeregjiltAimag |
| 5.6 | Тухайн онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн үр дүнг, хэрэгжилтийн явцад ЗДТГ болон ИТХ-аас хяналт, шалгалт хийх, тайлан мэдээллийг УМС-д оруулах; | Мэдээллийг байршуулах | 73 | 100 | Энд онд хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдэд хяналт, шалгалт хийх ажлыг хэсгийг захирамжаар баталсан. Энэ онд хийгдэх төсөл, хөтөлбөрүүд тендер зарлан гэрээ байгуулах шатандаа явж байгаа. |
| 5.7 | Өмнөх оны төвийн гүйцэтгэлээр бий болсон хөрөнгийн өмчлөл ашиглалтыг хүлээн авах комисс байгуулагдсан шийдвэр, хүлээн авсан акт, өмчлөлд бүртгэсэн, холбогдох этгээдэд хариуцуулсан нотлох баримтыг эргэж | Мэдээллийг байршуулах | 73 | 100 | 2023 онд хийсэн төсөл арга хэмжээ, ажлуудад гэрээ, гүйцэтгэл, хүлээн авсан акт зэрэгт үндэслэн өмчлөлд бүртгэх шийдвэр гаргуулан бүртгэлжүүлэн Удирдлага мэдээллийн системд бүрэн байршуулсан. https://onhs.mof.gov.mn/mis/Report/HeregjiltAimag |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | үзэх боломжтойгоор УМС-д байршуулах; | | | | |

ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГА Б.БАТЭРДЭНЭ

ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ ГАРГАСАН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Г.БАТЧИМЭГ